



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 12 сарын 31 өдөр

Дугаар А/592

Арвайхээр

Согтууруулах ундаа худалдах, түүгээр  
үйлчлэх тусгай зөвшөөрлийг шинээр  
олгохыг түр хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", "л", Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны "Норматив тогтоох тухай" А/272 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоог аймаг, нийслэл, суманд 1000 хүн ам тутамд 4 хүртэл байхаар тогтоож, нутаг дэвсгэрийн хэмжээнд дээрх норматив хязгаарт нийцүүлэн тусгай зөвшөөрөлтэй цэгийн тоог бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шийдвэр гарсны дагуу 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгохыг хориглосугай.

2.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумдын нутаг дэвсгэрт холбогдох хууль тогтоомжийг сурталчлах, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны "Журам шинэчлэн батлах тухай" 07/05 дугаар тогтоолоор батлагдсан журмыг шинэчлэн боловсруулж, батлуулах, дээрх тушаал шийдвэрийг хэрэгжүүлэх чиглэлээр судалгаа хийж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /А.Отгонцэцэг/-т даалгасугай.

3.Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй худалдаа үйлчилгээний цэгүүдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (О.Ганбат), Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101342

D:My Doc. Zahiramj. Zasag darga